



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Заг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/4/СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[Bayankhongor@audit.gov.mn](mailto:Bayankhongor@audit.gov.mn)

Баянхонгор хот  
2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга  
тэргүүлэх аудитор : Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Аудитор: Д.Цэцэгмаа

Утас: Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	4
2. Аудитын тайлан .....	6
2.1. Оршил.....	6
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	6
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	9
2.8.1 Мөнгөн хөрөнгө.....	9
2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт .....	9
2.8.3 Авлага .....	9
2.8.4 Урьдчилгаа .....	10
2.8.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт .....	10
2.8.6 Бараа материал .....	10
2.8.7 Үндсэн хөрөнгө .....	10
2.8.8 Өр төлбөр .....	11
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо.....	11
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	12
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	13
2.11. Шилэн дансны мэдээлэл .....	14
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	14
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	14
3. Менежментийн захидал .....	15
3.1. Орлого төвлөрүүлэлттэй холбоотой асуудал .....	15
3.2 .Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал .....	15

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	16
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	16
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан .....	17
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	21
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	24
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	25
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	29
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	31

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

## 1. Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

ЗАГ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Д.МӨНХНАСАН ТАНАА

2020.03.23 № 1/350

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, 8.9.3-д заасны дагуу Заг сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Заг сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Заг сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020278

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг хариуцлага

Заг сумын Засаг дарга нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

## 2. Аудитын тайлан

### 2.1. Оршил

Заг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Д.Мөнхнасанд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Заг сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Заг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 9-өөс 2020 оны 03 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор Д.Цэцэгмаа гүйцэтгэв.

Заг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 1/09 тоот албан бичгээр ирүүлж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2020 оны 03 дугаар сарын 09-нд ирүүлсэн байна.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

#### **2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Заг сумын Засаг даргын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу боловсруулагдсан байна.

Заг сумын Засаг даргын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба 2019 онд тус сумын дотоод төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн ба хяналт шалгалтаар зөрчил, дутагдал илрээгүй байна.

#### **2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Заг сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

#### **2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2018 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3548,8 сая төгрөгийн 1.0 хувь буюу 17,7 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2438,7 сая төгрөгийн 1.0 хувь буюу 24,4 сая төгрөгөөр тооцсон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

#### **2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа төсвийн байгууллага 6, тусгайн сан 2, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс ЗДТГ, ЭМТ, Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэгийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Соёлын төв, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж санал дүгнэлт өгөөгүй байна.

Аудитад хамрагдаж дүгнэлт гаргасан 4 санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Заг сумын ТТЗ-чийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт 28,8 сая төгрөгийн алдаа илэрч, холбогдох байгууллагуудын аудитлагдсан санхүүгийн тайланд залруулга хийв.

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд ИТХ-ын хөрөнгийн дахин үнэлгээ дансны эхний болон эцсийн үлдэгдэл 0,3 сая, Соёлын төвийнх 0,5 сая төгрөгөөр тусгагдсан байхад байгууллагуудын аудитлагдсан тайланд тусгагдаагүй байсныг аудитлагдсан тайлангуудад залруулга хийлгэсэн
- Соёлын төвийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй олгогдсон 28,8 сая төгрөгийн Пургон автомашиныг хөрөнгийн орлого дансанд бүртгэсэн байсныг залруулж үнэ төлбөргүй орлого дансанд бүртгүүлж залруулсан.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

ТТЗ-чийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар акт тогтоогоогүй, албан шаардлага өгөгдөөгүй. Харин харьяа байгууллагуудын санхүүгийн аудитаар нийт 89,0 сая төгрөгийг алдаа зөрчил илэрсэн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд 30,5 сая төгрөгийн алдааг залруулсан байна.

Сая төгрөгөөр

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдааны дүн		Үүнээс: Залруулсан алдааны дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
1.Ерөнхий боловсролын сургууль	1	19,8	1	19,8
2.Цэцэрлэг	1	10,7	1	10,7
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>30,5</b>	<b>2</b>	<b>30,5</b>

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн залруулагдаагүй алдаа зөрчил

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд залруулагдаагүй дараах 58,5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрлээ. Үүнд:

Сая төгрөгөөр

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1.Сумын ЗДТГ	3	11.89			1	8.89	2	3.0
2.ЭМТ	4	7.97	2	6.8			2	1.17
3.Соёлын төв	2	0.56	1	0.56			1	0
4.СХС	2	36.2	1	4.9	1	31.3		
5.ОНХС	1	1.9	1	1.9				
<b>ДҮН</b>	<b>12</b>	<b>58.52</b>	<b>5</b>	<b>14.16</b>	<b>2</b>	<b>40.19</b>	<b>5</b>	<b>4.17</b>

## 2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

### 2.8.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 113,9 сая, эцсийн үлдэгдэл 217,9 сая төгрөг болж, 104,0 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	-	-	-	-
Төрийн сангийн дансанд байгаа бэлэн мөнгө	113,9	217,9	104,0	100,0
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-	-
Хадгаламж	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>113,9</b>	<b>217,9</b>	<b>104,0</b>	<b>100,0</b>

*Эх сурвалж: Заг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 178,0 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд, үүнээс ОНХС-гийн харилцах дансанд 118,5 сая, СХС-гийн харилцах дансанд 59,5 сая төгрөг, ОНХО-ын 39,9 сая төгрөг тус тус байршиж байна.

ОНХО-ын дансн үлдэгдэл нь оны эхэнд 23,7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, тайлант хугацаанд 52,4 сая төгрөг, ИТХ-ын өмнөх оны нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэлтийн 1,0 сая төгрөг, санхүүгийн дэмжлэгээр 526,8 сая төгрөг тус тус төвлөрч, 580,5 сая төгрөгийн санхүүжилт, үүнээс орон нутгийн орлогоос 53,7 сая төгрөгийг олгож, төсөвт байгууллагууд 16,5 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж, үлдэгдэл 39,9 сая төгрөг байна.

Замд яваа мөнгөн хөрөнгө, хадгаламжийн дансанд мөнгөн хөрөнгө байхгүй байна.

### 2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны эхний, эцсийн үлдэгдэл байхгүй.

### 2.8.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 167,6 сая, эцсийн үлдэгдэл 132,4 сая төгрөг болж 35,2 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагаас авах авлага		0,4	0,4
Төлбөртэй үйлчилгээний авлага			
Татаас, санхүүжилтийн авлага			
Зээлийн хүүгийн авлага	157,0	128,9	-28,1
Бусад авлага	10,6	3,1	-7,5
Зээлийн авлага			
<b>Дүн</b>	<b>167,6</b>	<b>132,4</b>	<b>-35,2</b>

*Эх сурвалж: Заг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 132,0 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Сум хөгжүүлэх сангийн зээлийг 3 жилийн хугацаатай олгосон зээлийн авлагын үлдэгдэл 128,9 сая төгрөг
- ОНХС-гаас малжуулах төслөөр 3 жилийн хугацаатай олгосон зээлийн авлага 3,1 сая төгрөг байгаа нь тул насжилт өндөртэй авлага үүсэхэд нөлөөлж байгаа болно.

- Байгууллагаас авах авлагын үлдэгдэл 0,4 сая төгрөг нь шатахууны нөөц үүсгэх зорилгоор бэлтгэн нийлүүлэгч байгууллагад мөнгө шилжүүлж авлагаар бүртгэсэн байна.

#### 2.8.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний, эцсийн үлдэгдэл байхгүй байна.

#### 2.8.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын эхний, эцсийн үлдэгдэл байхгүй .

#### 2.8.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 139,4 сая, эцсийн үлдэгдэл 152,6 сая төгрөг болж, 13,2 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
1.Тусгай зориулалтын материал	126,9	133,3	6,4
2.Эм, ороох боох материал	0,4	1,4	1,0
3.Хангамжийн материал	11,1	16,9	5,8
<b>Дүн</b>	<b>139,4</b>	<b>152,6</b>	<b>13,2</b>

*Эх сурвалж: Заг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материалын үлдэгдэлд тайлант онд тусгай зориулалтын материал 27,9 сая төгрөгөөр нэмэгдэж, 17,6 сая төгрөгийн зарцуулалт гарч нөөцийг 10,3 сая төгрөгөөр, бусад хангамжийн материал 11,4 сая төгрөгийн худалдан авалт хийж, 7,6 сая төгрөгийн зарцуулалт гарч нөөцийг 3,8 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн нь бараа материалын үлдэгдэл өсөхөд нөлөөлжээ. Тусгай зориулалтын материалын үлдэгдлийн өсөлтөд нэгтгэлд хамрагдсан байгууллагуудаас Цэцэрлэгийн тусгай зориулалтын материал тайлант онд 5,0 мянган төгрөгөөр нэмэгдэж 3,4 сая төгрөгөөр хасагдсан, Соёлын төвийнх 2,5 сая төгрөгөөр , ЗДТГ-ынх 1,5 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь үлдэгдэлд нөлөөлсөн байна. Бусад хангамжийн материалын үлдэгдэл өссөн нь сургуулийн үлдэгдэл 2,4 сая, ЭМТ-ийнх 1,2 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар бий болсон ашиглагч байгууллагад шилжүүлээгүй бараа материалын дансанд бүртгэлтэй хөрөнгө байхгүй байна.

#### *Аудитын илрүүлэлт:*

*Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар бараа материалтай холбоотой алдаа, зөрчил гараагүй .*

#### 2.8.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4556,8 сая, эцсийн үлдэгдэл 4514,1 сая төгрөг болж, 42,7 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
1.Барилга байгууламж	2961,4	2942,8	-18,6

БНА-2020/4/СТА-ТТЗ

2.Тээврийн хэрэгсэл	196,0	199,8	3,8
3.Машин,тоног төхөөрөмж	597,6	551,5	-42,3
4.Тавилга, эд хогшил	101,0	107,1	6,1
5.Дуусаагүй барилга байгууламж	138,1	138,1	0
6.Номын фонд	28,9	17,6	-11,3
7.Бусад үндлсэн хөрөнгө	482,0	505,2	23,2
8.Программ хангамж	2,9	2,9	0
9.Бусад биет бус хөрөнгө	48,7	48,7	0
<b>Дүн</b>	<b>4556,8</b>	<b>4514,1</b>	<b>-42,7</b>

Эх сурвалж: Заг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 40.7 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 14.3 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 96.8 сая төгрөгөөр нэмэгдсэн, балансаас баланст шилжүүлсэн 35.5 сая, акталсан 140.5 сая, 18,6 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд 138,1 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь өмнөх онуудад ОНХС-гийн хөрөнгийн санхүүжилтээр Ахмадын өргөөний өргөтгөл нэртэй ажил хийгдсэн боловч төсөвт өртгийн маргааны улмаас барилгын ажил зогсож, олгосон санхүүжилтийн хэмжээгээр дуусаагүй барилга дансанд бүтгэсэнтэй холбоотой байна.

#### Аудитын илрүүлэлт:

Аудитаар Соёлын төвд олгогдсон 28,0 сая төгрөгийн Пургон автомашиныг Хөрөнгийн орлого дансанд бүртгэсэн алдаа илэрснийг Үнэ төлбөргүй орлого дансанд залруулан бүртгүүлэв.

#### 2.8.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл байхгүй, эцсийн үлдэгдэл 0,3 сая төгрөг болж 0,3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	0	0,3	0,3	100,0
1.Ажиллагсадтай холбогдсон өглөг	0	0,3	0,3	100,0
<b>Нийт дүн</b>	<b>0</b>	<b>0,3</b>	<b>0,3</b>	<b>100,0</b>

Эх сурвалж: Заг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл нь ЭМТ-ийн нийгмийн даатгалын байгууллагад төлөх шимтгэлийн дутуу төлөлтөөс үүссэн үлдэгдэл өглөг байна.

#### 2.8.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4092,1 сая, эцсийн үлдэгдэл 4046,4 сая төгрөг болж, 45,4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 31. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/ бууралт -/	Дүнд эзлэх хувь
----------	----------------	-----------------	-----------------------	-----------------

Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1483,7	1483,7	0	36,7
Өмч /төрийн/ /ТӨҮГ/				
Өмч /хувийн/ /ТӨҮГ/				
Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/				
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/				
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/				
Хуримтлагдсан үр дүн	767,9	722,2	-45,7	17,8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1840,5	1840,5	0,	45,5
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга				
<b>Дүн</b>	<b>4092,1</b>	<b>4046,4</b>	<b>-45,7</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Заг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал данс дүнгээрээ 45,7 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн -45,7 сая төгрөгөөр илэрхийлэгдсэнтэй холбоотой байна.

Бодлогын өөрчлөлт алдааны залруулга гараагүй.

## 2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Заг сумын ИХТ-ын хуралдааны 2018.12.17-ны өдрийн 12/07 тоот тогтоолоор сумын татварын орлогыг 35,4 сая , татварын бус орлогыг 6,1 сая, үүнээс төсөвт байгууллагын өөрийн орлогоор 0,6 сая, нийт 41,5 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөө баталжээ. Гүйцэтгэлээр 52,6 сая төгрөгийн орлого төвлөрч төлөвлөгөөг 11,1 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр төлөвлөгөө гүйцэтгэлийг харьцуулж үзэхэд ХХОАТ /хадгаламжийн хүүгийн орлого/ 8,1 сая, татварын бус орлого буюу торгуулийн орлого 4,9 сая төгрөгөөр тус тус давж биелэн, бусад татвар, төлбөр хураамжийн орлого 1,1 сая, хөрөнгийн татвар 0,4 сая төгрөгөөр , төсөвт байгууллагын өөрийн орлого 0,4 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>А. Нийт орлогын дүн</b>	<b>41,5</b>	<b>52,6</b>	<b>11,1</b>	<b>100,0</b>
1.Татварын орлого :	35,4	42,0	6,6	79,8
а/ Үйл ажиллагааны орлого	9,0	9,9	0,9	23,6
б/Хөрөнгийн орлого	20,0	27,2	7,2	64,8
в/Бууны албан татвар	2,0	1,6	-0,4	3,8
г/Бусад татвар, төлбөр хураамж	4,4	3,3	-1,1	7,8

д/Бусад татвар		0,03	0,03	0,1
2.Татварын бус орлого	6,1	10,6	4,5	20,2
а/Торгуулийн орлого	5,5	10,4	4,5	98,1
б/ Төсөвт байгууллагын өөрийн орлого	0,6	0,2	-0,4	1,9

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 1720,9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1592,5 сая төгрөгийг урсгал зардалд, 128,4 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Заг сумын ИТХ-ын хуралдааны 2018,12,17-ны өдрийн 12/07 тоот тогтоолоор нийт зарлага санхүүжилтийг 1720,9 сая төгрөгөөр баталж, үүнээс аймгийн төсвөөс санхүүгийн дэмжлэгээр 527,8 сая төгрөг, ОНХС-аас 66,2 сая төгрөг, ТЗШ-ээр 936,6 сая төгрөг, ЭМД-аас 21,2 сая төгрөгийн санхүүжилт авах, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 0,6 сая төгрөг оруулж, СХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 40,0 сая төгрөг, ОНХС-гийн өмнөх оны үлдэгдлээс 57,7 сая, СХС-гийн өмнөх оны үлдэгдлээс 22,0 сая төгрөгийг зарцуулахаар эх үүсвэрийг баталжээ. Гүйцэтгэлээр 1551,5 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 169,3 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Хэмнэсэн зардлыг байгууллагаар нь авч үзвэл санхүүгийн дэмжлэгээр аймгаас авах 929,8 сая төгрөгийн урсгал зардлын санхүүжилт, 66,2 сая төгрөгийн ОНХС-гийн санхүүжилтийг бүрэн авсан ба төсөвт байгууллагууд батлагдсан төсвөөс 21,5 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн, ОНХС-гийн батлагдсан төвөөс 81,2 сая төгрөгийн ажил дутуу хэрэгжсэн, СХС-гийн 62,0 сая төгрөгийн зээл олгогдоогүй, ЭМД-аас авах санхүүжилтийг 7,2 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлсэнтэй холбоотой

Нийт зардлын 929,8 сая төгрөгийг ТЗШ-ээс, 645,8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 124,1 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас, 21,1 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр ТЗШ-ийн болон орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг бүрэн авч харин эрүүл мэндийн даатгалаас авах санхүүжилтийг 13,9 сая төгрөгөөр дутуу, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжүүлэх эх үүсвэр 53,9 сая төгрөгөөр тасарсан байна.

Сумын ЗДТГ-т төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 0,6 сая төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөө батлагдсанаас 0,2 сая төгрөгийг төвлөрүүлсэн бусад байгууллагад үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө байхгүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1551,6 сая төгрөг буюу 90,1 хувьтай буюу батлагдсан төсвийг 169,3 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Хэмнэсэн зардлыг байгууллагаар нь авч үзвэл санхүүгийн дэмжлэгээр аймгаас авах 929,8 сая төгрөгийн урсгал зардлын санхүүжилт, 66,2 сая төгрөгийн ОНХС-гийн санхүүжилтийг бүрэн авсан ба төсөвт байгууллагууд батлагдсан төсвөөс 21,4 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн, ОНХС-гийн батлагдсан төвөөс 81,2 сая төгрөгийн ажил дутуу хэрэгжсэн, СХС-гийн 62,0 сая төгрөгийн зээл олгогдоогүй, ЭМД-аас авах санхүүжилтийг 7,2 сая төгрөгөөр дутуу санхүүжсэнтэй холбоотой байна.

**Нэмэлт төсөв:** Дээд шатны төсөв захирагчаас болон бусад эх үүсвэрээс 35,8 сая, төсөвт байгууллагын үндсэн бус үйл ажиллагаанаас 0,5 сая, нийт 35,7 сая төгрөгийн эх үүсвэр төвлөрсөн байна.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн бараа үйлчилгээний зардалд 33,6 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 2,0 сая төгрөгийг тус тус зарцуулан үлдэгдэл 0,1 сая төгрөгийг буцаан төвлөрүүлжээ

## 2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар нэгтгэсэн тайлангийн хувьд анхаарах асуудал байхгүй болно.

БНА-2020/4/СТА-ТТЗ

## 2.11. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 146 мэдээллийг хугацаанд нь, 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	13	13	9	2	2
2	Хагас жил	3	3	2	1	
3	Улирал бүр	2	8	7	1	
4	Сар бүр	5	60	59	1	
5	Тухай бүр	6	72	69	3	
	Нийт	29	156	146	8	2

## 2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайланд итгэл үзүүлж аудит хийгдээгүй тул зөвлөмж өгөгдөөгүй байна.

## 2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Заг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБООУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Заг сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНБООУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Заг сумын Засаг даргын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1. Орлого төвлөрүүлэлттэй холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

1. Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс тайлант онд 40,0 сая төгрөгийн орлого төвлөрүүлж 62,0 сая төгрөгийг зээлд олгохоор төлөвлөсөн боловч 31,2 сая төгрөгийн зээл төлөгдөж, 36,2 сая төгрөгийн зээл, зээлийн хүү хугацаандаа төлөгдөөгүйгээс төлөвлөсөн хэмжээнд зээл олгогдоогүй байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг гарахгүй байх

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх арга хэмжээ авч эх үүсвэрийг бүрдүүлсний дараа зээлийг зохих журмын олгож төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэхэд анхаарч ажиллах

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Зөвшөөрсөн.

#### **3.2 .Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

##### **3.2.1 Илрүүлэлт:**

1.ТТЗ-чийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 14,2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоогдсоны 52,1% нь буюу 7,4 сая төгрөгийн төлбөрийн акт нь батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсантай холбоотой зөрчил байна.

##### **3.2.2 Эрсдэл:**

Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, батлагдсан төсвийг хэтрүүлэх

### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, Төсвийн тухай хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж ажиллах

### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн мөрөөр зохиосон ажил гарсан үр дүнгийн талаар Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 6 дугаар сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-1А

### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>420891452.06</b>	<b>502799419.91</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	113894292.84	217868180.78
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	113894292.84	217868180.78
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	113894292.84	217868180.78
31211	Төрийн сангийн харилцах	113894292.84	217868180.78
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	167620410.00	132367462.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	10622000.00	3487900.00
3351	Байгууллагаас авах авлага		414900.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	10622000.00	3073000.00
<b>336</b>	<b>Зээлийн авлага</b>	156998410.00	128879562.00
<b>3361</b>	<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	156998410.00	128879562.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	156998410.00	128879562.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	139376749.22	152563777.13
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	127238332.04	134689206.95
35110	Тусгай зориулалттай материал	126853104.04	133268877.95
35130	Эм боох материал	385228.00	1420329.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	11138417.18	16874570.18
35410	Бичиг хэргийн материал	78100.00	554500.00
35420	Аж ахуйн материал	4295332.00	4774705.00
35440	Түлш, шатах тослох материал	37500.18	0.18
35460	Хүнсний материал	1131485.00	2137165.00
35470	Бусад хангамжийн материал	5596000.00	9408200.00
35600	Мал амьтад	1000000.00	1000000.00

2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3671256558.12</b>	<b>3543897078.63</b>
